3.2.1.6	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан тайлагнах	Үйл ажиллагаа	21 аймаг	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжилт болон газар олголтын байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.	Эхний хагас жилд: Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнасан байна. Жилийн эцэст: Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнах; Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор цахим	Орхон аймгийн хэмжээнд 10 арга хэмжээний хүрээнд 132 нэгж талбарын 4,074 га газарт тухайн жилийн төлөвлөгөө батлагдсан. Үүнээс 3 арга хэмжээ 100% , 7 арга хэмжээ хэрэгжих шатандаа явж байгаа бөгөөд дунджаар 40% биелэлттэй байна. Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд зөрчил гараагүй байна.	100

					системд бүрэн оруулж дууссан байна.		
3.2.1.7	Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах, боловсруулах, дүгнэлт авах, батлуулах, батлагдсан төлөвлөгөөг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах.	Үйл ажиллагаа	21 аймаг	МУ-ын 3Г-ын 2024 оны 92 дугаар тогтоол	Эхний хагас жилд: Газар зохион байгуулалт хийх журмын хугацааг баримтлан сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулах, иргэд, олон нийтээс төлөвлөгөөнд санал авах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах. Жилийн эцэст: Газар зохион байгуулалт хийх журмын хугацааг баримтлан сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, цахим системд байршуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах; 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг аймгийн хэмжээнд хянаж ГЗБГЗЗЕГ-аас дүгнэлт авах, тухайн шатны ИТХ-аар батлуулах ажлыг зохион байгуулж, батлагдсан төлөвлөгөөг ГЗБГЗЗЕГ-т ирүүлсэн байна.	Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын захирамжаар 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, санал авах ажлын хэсгийг байгуулсан. Багуудын ажлын албаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэн, QR кодыг цахимд байршуулан санал авч ажиллаж байна. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд байршуулсан 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд цахимаар 21 өргөдөл ирснээс эзэмшил газрын зориулалт өөрчлөх хүсэлт-2, шинээр гэр бүлийн хэрэгцээний газар авах хүсэлт-15, А1001 зам дагуу аж ахуйн зориулалтаар газар эзэмших хүсэлт-4, гэр орон сууц хашааны газар хүссэн цаасан өргөдөл-6 ирсэн байна. Багийн иргэдийн нийтийн хурлаар оруулах 8 өргөдөл байна. Монгол улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх 695 иргэний өргөдлийг сумын төвийн суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгүй байршилд төлөвлөсөн шалтгаанаар Засгийн газрын 2025 оны 119 дүгээр тогтоолоор хасагдсан бөгөөд 2026 оны төлөвлөгөөнд дахин тусгахаар төлөвлөж байна.	100
3.2.1.3	Орон нутгийн онцлогт нийцүүлэн Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журмыг боловсруулан, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах	Үйл ажиллагаа	21 аймаг	-	Эхний хагас жилд: Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журмын төслийг боловсруулж, хянуулан, санал авах ажлыг зохион байгуулсан байна. Жилийн эцэст: Журмын төслийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна.	Сум орон нутгийн онцлогт нийцүүлэн Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журмын төсөлд холбогдох 4 байгууллагуудаас санал авсан бөгөөд тус журмын төслийг Жаргалант сумын Засаг даргын Тамгын газарт "Бэлчээр ашиглах, хамгаалах, сайжруулах журам"-ийн хүргүүлсэн. Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар журмын төслийг сумын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байршуулан иргэдээс нээлттэй санал авч, сумынхаа	90

						онцлог асуудлуудыг тусган нэгтгэж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, батлуулах ажлыг зохион байгуулан хамтран ажиллах талаар 2025 оны 04 дүгээр сары 17-ны өдрийн 249 дугаар албан бичгээр хүргүүлэн ажилласан.	
3.2.1.8	Сумдын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах	Үйл ажиллагаа	21 аймаг	2024 онд 2 сургалт зохион байгуулсан.	Улиралд нэг удаа цахим болон танхимаар сургалт зохион байгуулсан байна. Сургалт зохион байгуулсан тайлан мэдээг тухай бүр тайлагнасан байна.	Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын газрын даамлуудад 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр "Газар зохион байгуулалт, төлөвлөлт", 03 дугаар сарын 13-ны өдөр "Кадастр"-ын асуудлаар сургалтыг зохион байгуулсан.	100
3.2.1.9	Монгол Улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын саналыг нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх.	Үйл ажиллагаа	21 аймаг	2024 онд аж ахуйн зориулалтаар 5 иргэнд өмчүүлсэн.	Жилийн эцэст: Монгол Улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг сум тус бүрээр нэгтгэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, тогтоолыг ГЗБГЗЗЕГ-т ирүүлсэн байна.	хугацаа болоогүй.	-
Стратеги төлөвлөгөөний зорилго 3.3. Геодези, зураг зүйн тухай хуулийг шинэчлэн батлуулах							
3.3.1	Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах,	Үйл ажиллагаа	Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийн үзэл баримтлал	Геодези зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан.	Геодези, зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулсан байна.		
3.3.1.2	Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд хэлэлцүүлэх	Үйл ажиллагаа	1 хуулийн төсөл	Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг 2023 онд олон нийтээр хэлэлцүүлсэн.	Эхний хагас жилд: Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах, сурталчлах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангахад хамтран ажиллана.	Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг албан хаагчдад танилцуулсан бөгөөд 2 санал гаргасан бөгөөд ГЗБГЗЗЕГ-луу 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 424 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 3.7. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах							
3.7.1	Хяналт шалгалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд	Үйл ажиллагаа	Шинэчлэн батлагдсан эрсдэлийн	2024 онд Салбарын хяналт	Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд		

	шаардагдах баримт бичгийг шинэчлэн боловсруулах		шалгуур үзүүлэлт-1 Батлагдсан хяналтын хуудас-1	шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах журам", "Хяналт шалгалтын баримт бичгийг бүртгэх, дугаар олгох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулсан.	хамааруулах шалгуур үзүүлэлт, шалгалтад хамрагдах объектыг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, хяналт шалгалтыг үр дүнтэй, ил тод, нээлттэй болгох, аливаа нөлөөллөөс ангид, адил тэгш, хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.		
3.7.1.3	Газар, геодези, зурагзүйн хяналтын улсын (ахлах) байцаагч нарт зориулсан чадавхжуулах сургалтад хамрагдах	Үйл ажиллагаа	Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын тоо	Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчдад 2024 онд нийт 5 удаагийн цахимаар болон танхимаар сургалт зохион байгуулсан.	Батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу чадавхжуулах сургалтад идэвх, санаачилгатай оролцсон байх.	2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр ГЗБГЗЗЕГ-ын Салбарын хяналт шалгалтын хэлтсээс зохион байгуулсан "Газрын кадастрын мэдээллийн системийн тухай" цахим сургалт, 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын цахим систем, ГЗБГЗЗЕГ-аас 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан "Кибер аюулгүй байдал"-ын цахим сургалтад газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан шинэчилсэн журмаар гарах ХАСХОМ-н сургалтад улсын ахлах байцаагч, 3 хяналтын улсын байцаагч улсын байцаагч нарыг хамруулсан.	100
3.7.1.4	Орон нутгийн хэмжээнд Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн рийл, постер, мэдээ мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэх	Үйл ажиллагаа	Батлагдсан төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээний тоо	2024 онд хяналт шалгалтын зөвлөмж, 45 минутын видео зааврыг бэлтгэж хүргүүлсэн.	Газрын харилцааны салбарт түгээмэл гарч байгаа зөрчлийг бууруулах зорилгоор иргэд, олон нийтэд урьдчилан сэргийлэх рийл, постер, мэдээ мэдээллийг хүргэсэн байна.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас зохион байгуулсан газрын харилцааны салбарт түгээмэл гарч буй зөрчлийг бууруулах зорилгоор иргэд, олон нийтэд урьдчилан сэргийлэх зорилгоор Орхон аймгийн ГХБХБГ-ын erdenet.gazar.gov.mn цахим хуудасад 3 төрлийн мэдээ, мэдээлэл, Баян-Өндөр сумын албан ёсны цахим хуудсанд 10	100

						төрлийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хуваалцсан.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 3.7. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах							
3.7.5	Газрын зөрчил, маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо	2024 онд иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 218 албан бичиг, иргэний 63 өргөдлийг шийдвэрлэсэн.	Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргах, нотлох баримтыг хүргүүлсэн байна.		
3.7.5.1	Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах.	Үйл ажиллагаа	Шийдвэрлэсэн албан бичиг, тушаалын биелэлт	Шинжээчийн дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.	Эхний хагас жилд: Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажлын хэсэг байгуулах тухай газрын даргын тушаалын төсөл боловсруулан, ажлын хэсгийг байгуулсан байна. Шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажлын хэсэг байгуулах тухай газрын даргын тушаалын төсөл боловсруулан, ажлын хэсгийг байгуулсан байна. Шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт холбогдох болон аймгийн Засаг дарга, Баян-Өндөр сумын Засаг даргад холбогдох Иргэн, Захиргаа, Эрүүгийн хэрэгт Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн томилогдон ажиллаж байгаа бөгөөд шаардлагатай зарим хэрэгт Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн болон төлбөрийн мэргэжилтнийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хамт томилон ажиллаж байна. 2025 оны байдлаар: 1. Иргэн Наранбаатарын нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт холбогдох Орхон аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн "Газар эзэмшүүлэх тухай" А/598 дугаар захирамжийг хүчингүй болгуулах захиргааны хэрэг шүүхэд хянан хэлэлцэгдэж байа. 2. Иргэн В.Баярсайханы нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Засаг даргад холбогдох Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 347	100

						дугаар албан бичгийг илт хууль бус болохыг тогтоолгох, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянбулаг баг, Ургацын гудамжинд байрлах 534 м.кв газрыг нэхэмжлэгч В.Баярсайханд өмчлүүлэх шийдвэр гаргахыг хариуцагчид даалгах нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан хэлэлцэгдэж байна. 3. Иргэн А.Ариунтунгалагийн нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэн, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт холбогдох засаг дарга уламжлахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, газар эзэмшүүлэх тухай захирамж гаргахыг Баян-Өндөр сумын Засаг даргад даалгах захиргааны хэргээс анхан шатанд буцаасан бөгөөд хянан хэлэлцэгдэж байна. 4. "Хуанлу Хуантун" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт холбогдох Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 22 дүгээр сарын 29-ний өдрийн А/625 дугаар захирамжийг хүчингүй болгуулж, газар ашиглах эрхийг сэргээлгэх, газар ашиглах эрхийн гэрчилгээ гаргаж, гэрээ байгуулахыг даалгах тухай" нэхэмжлэлтэй захиргааны хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан. 5. "Сод-Өргөө" ХХК, "Төрийн банк" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Засаг даргад холбогдох "Сод-Өргөө" ХХК-ийн газар эзэмших эрх сунгахыг даалгах захиргааны хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан бөгөөд нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. 6. Иргэн З.Жаргалсайханы нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Засаг	
--	--	--	--	--	--	--	--

						даргад холбогдох Газар эзэмшүүлэх тухай гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийг шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. 7. “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар холбогдох Газрын төлбөр нэхэмжилсэн мэдэгдлийг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийг захиргааны 3 шатны шүүхээс бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж, Газрын төлбөр нэхэмжилсэн 638 сая төгрөгийн мэдэгдлийг хэвээр үлдээсэн. 8. “Маргад тамир” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Засаг даргад холбогдох Орхон аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/756 дугаартай захирамжийг хүчингүй болгож, зөрчигдсөн эрхийг хамгаалах” нэхэмжлэлийг захиргааны хэргийн 2 шатны шүүхээс нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж Засаг даргын захирамжийг хэвээр үлдээсэн. Мөн 2025 онд шинжээчээр тус газрыг томилоогүй байна. 2025 онд Захиргааны хэргийн шүүхэд 2, Иргэний хэргийн шүүхэд 6, Цагдаагийн газар төрлийн нотлох баримтыг гарган хүргүүлсэн.	
3.7.3.5	Хот тосгон, бусад суурины доторх Авто замын хамгаалалтын бүсийг зураглах, тогтоох ажлыг зохион байгуулан, батлуулах, батлагдсан шийдвэр болон хамгаалалтын бүсийг цахим системд байршуулах.	Үйл ажиллагаа	21 аймаг 330 сум	Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар хурлын тэмдэглэлд дурдсан Зам тээврийн яамны ирүүлсэн Авто замын мэдээллийг	Эхний хагас жилд: Аймаг, сумын хот, суурины авто замын зурвас газрын өргөнийг холбогдох норм, дүрмийн хүрээнд зураглан, батлуулах ажлыг зохион байгуулах. Жилийн эцэст: Хамгаалалтын бүсийн мэдээллийг цахим системд оруулах ажлыг зохион байгуулах.	Эхний ээлжид Орхон аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй улсын чанартай А1001, А1002 авто замыг хамгаалах зурвас бүхий 391.7 га газрыг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/860 аймгийн Засаг даргын захирамжаар Зам, тээврийн хөгжлийн яамд эзэмшүүлсэн. Орон нутаг доторх 50 км гаруй авто замыг хамгаалалтын зурвас тогтоох ажил хийгдэж байна.	100

3.8.1.1	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Бэлчээрийн фото мониторингийн цэгийн тоо	2024 онд 2 сумын бэлчээрийн газарт фото мониторингийн ажлыг зохион байгуулж 10 цэгийн мэдээллийг шинэчлэн бүрдүүлж тайлаг гаргасан.	Жилийн эцэст: 2025 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан нэгтгэж, холбогдох зөвлөмжийг гаргаж, газрын мониторингийн цахим системд бүрэн оруулж, тайланг 10 сарын 01-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	хугацаа болоогүй.	-
3.8.1.2	Атар газраас тариалангийн ангилалд шилжүүлэх саналыг судалж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санал, дүгнэлт боловсруулах	Үйл ажиллагаа	Ирүүлсэн саналын тоо	"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг гаргаж, тус газрын 2024 оны 1/2901 тоот албан бичгээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.	Эхний хагас жилд: Атар газрын ангилал шилжүүлэхээр холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг судлан шийдвэрлэсэн байна. Жилийн эцэст: Атар газрын ангилал шилжүүлэхээр холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг судлан шийдвэрлэсэн байна.	Атар газраас тариалангийн ангилалд шилжүүлэхээр 2023 онд 65.8 га газрын судалгаа гарган Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан ч газрын нэгдмэл сангийн ангилал таарахгүй гэсэн дүгнэлтээр Засгийн газраас буцаагдсан. Мөн 2025 онд Жаргалант сумын Нарангийн энгэрт байрлах 20 га газарт мэргэжлийн байгууллагаар хөрсний шинжилгээ хийлгэсэн бөгөөд Эрчим хүчний яамнаас дэмжигдсэн Жаргалант суманд 200 Мвт хүчин чадалтай, 800 МТв.цагийн багтаамжтай эрчим хүчний хуримтлуурын нарны цахилгаан станц байгуулах ажлын хүрээнд тухайн газрыг дуудлага худалдааны журмаар ашиглуулахаар сумын ИТХ-ын 2025 оны 04 сарын 22-ний өдрийн 03/05 дугаар тогтоолоор 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт тодотголд оруулан төлөвлөсөн.	100
3.8.1.3	Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг боловсруулж хүргүүлэх	Үйл ажиллагаа	Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайлан	Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан хэвлэгдсэн.	Эхний хагас жилд: Газрын нэгдмэл сангийн 2024 оны улсын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд Газарт учирсан хохирлын ГНСТ-9 тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ГНСТ-10 тайланг нэгтгэн гаргаж,	Аймгийн хэмжээнд Газарт учирсан хохирлын ГНСТ-9 тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ГНСТ-10 тайланг нэгтгэн гаргаж, газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	100

					ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн байна.		
--	--	--	--	--	-------------------------------------	--	--

ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 4.1. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.							
4.1.1	Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Тухай бүр	-	Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.		
4.1.1.1	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Тухай бүр	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд газрын дарга 6 удаагийн тушаалаар шинэчлэн баталсан.	Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг өөрчлөн баталсан тул Газрын даргын тушаалаар 2025 оны 01 дүгээр сарын 01-ны А/01 дүгээр тушаалаар албан хаагчийн цалингийн санг шинэчлэн баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 сарын 31-ний өдрийн 03/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тушаалыг газрын даргаар 2025 оны А/03 тушаалаар шинэчлэн гарган мөрдлөг болгон ажиллаж байна.	100

4.1.1.3	Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Сул болон эзгүй орон тоо	2024 онд 2 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбарт 4 удаа захиалга өгч зарлуулан сул орон тоог нөхсөн.	Эхний хагас жилд: Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна Жилийн эцэст: Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна.	Усан хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагчийн сул орон тооны захиалгыг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсний дагуу тусгай шалгалтыг зохион байгуулан 2024 оны 96 дугаар тогтоолоор нэр дэвшүүлэн 2025 оны 01 сарын 15-ны өдөрт газрын даргын тушаалаар Усан хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагчийг томилсон. Одоо сул орон тоо байхгүй.	100
4.1.1.4	"Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо" цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчлэх	Үйл ажиллагаа	Албан хаагчийн тоо	-	"Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо" цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилсэн байна.	"Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо" цахим системд байгууллагын 26 албан тушаалын тодорхойлолтыг нэг бүрчлэн шивж оруулан баталгаажуулсан бөгөөд программд баталгаажуулалтын төрөл орж ирснээр 84 гаруй удаа хандалт хийн албан хаагчийн мэдээллийг баталгаажуулсан. Мөн албан хаагчийн мэдээллийг тухай бүр оруулан ажиллаж байна.	100
4.1.1.5	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Төлөвлөсөн арга хэмжээний тоо	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" /2021-2025/-ыг баталсан.	Жилийн эцэст: "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд тайланг Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр дотоод мэйлээр хүргүүлсэн. Мөн тус хөтөлбөрийн нийгмийн дэмжлэгт хамрагдах шаардлага хангасан 5 албан хаагчийн судалгааг хүргүүлсэн	-

4.1.1.7	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах	Үйл ажиллагаа	Тайлангийн тоо	2024 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан байна. Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна.	Байгууллагын даргаар 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр "Авлигатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г 12 заалтын хүрээнд батлуулан хэрэгжилтийг ханган тайланг хагас жилээр гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	100
4.1.1.9	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх	Үйл ажиллагаа	Мэдүүлгийн тоо	2024 онд 30 төсөл арга хэмжээг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж комиссын гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг давхардсан тоогоор 450 хүн мэдүүлсэн.	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	Аймгийн Засаг даргын А/580 захирамжаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүний ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэн ажилласан мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.11 дэх заалтын хүрээнд 2023, 2024, 2025 оны хагас жилийн байдлаар гаргаж ХББОСЯ-нд 2025 оны 04 дүгээр сарын 25-ны 277 дугаар албан бичгээр болон цахим хаягаар хүргүүлэн ажилласан.	100
4.1.1.10	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Мэдүүлгийн тоо	2024 онд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг мэдүүлдэг албан тушаалтан шинээр томилогдоогүй	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 1 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулж, 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 05/262 дугаар албан бичгээр ирсэн зөрчилгүй дүгнэлтийг үндэслэн албан хаагчийг томилсон.	100
4.1.1.11	Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх	Үйл ажиллагаа	Мэдээ, судалгааны тоо	-	Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын бүх төрлийн нэгдсэн судалгаа, мэдээллийг цуглуулж, нэгтгэн цаг хугацаанд нь ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Хүний нөөцийн чиглэлээр ирсэн 6 төрлийн судалгааг тухай бүр нь гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хүний нөөцийн цахим системд байгууллагын 26 албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулан, албан хаагчдад танилцуулан баталгаажуулан ажилласан.	100
Стратегийн төлөвлөгөөний зорилго 4.2. Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох							
4.2.5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагаа	12 удаа	-	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг заасан хугацаанд оруулсан байна.		

4.2.5.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагаа	Мэдээллийн тоо	нийт 28 үзүүлэлтийг сар бүр-4, хагас жил бүр-4, жил бүр-11, тухай бүр-9 үзүүлэлтийг сар бүр шинэчлэн, зохих нь хугацаанд байршуулан.	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр оруулж баталгаажуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх нийт мэдээллийг хуулийн хугацаанд оруулан, тайлагнаж байна. Шилэн дансны сайтад үйл ажиллагаа, худалдан авалт, хүний нөөц, төсөв санхүүгийн нийт 28 үзүүлэлтийг сар бүр-4, хагас жил бүр-4, жил бүр-11, тухай бүр-9 үзүүлэлтийг сар бүр шинэчлэн, зохих хугацаанд нь байршуулан шинэчлэн ажилласан.	100
4.2.6	Тогтоол шийдвэрийн, биелэлтэд хяналт тавих	Үйл ажиллагаа	Тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлсөн байдал	78 тогтоол шийдвэрийн биелэлтийг журамд заасан хугацаанд тайлагнасан.	Бүртгэлд авсан тогтоол шийдвэрийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд холбогдох газарт тайлагнасан байна.		
